



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/88/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Б.Нямдорж Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.28

№

148

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БАЯН-УУЛ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07022275

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал.....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	110,896,397.46	115,457,347.68
35	БАРАА МАТЕРИАЛ	110,896,397.46	115,457,347.68
351	Түүхий эд материал	5,705,462.00	8,881,149.32
35110	Тусгай зориулалттай материал	5,228,412.00	7,689,049.32
35130	Эм боох материал	477,050.00	1,192,100.00
354	Хангамжийн материал	105,190,935.46	106,576,198.36
35410	Бичиг хэргийн материал	2,529,800.00	2,968,060.00
35420	Аж ахуйн материал	71,005,835.46	64,937,353.36
35430	Сэлбэг хэрэгсэл	1,386,000.00	1,386,000.00
35440	Түлш, шатах тослох материал	20,470,500.00	23,864,000.00
35450	Барилгын засварын материал	5,330,000.00	11,130,500.00
35460	Хүнсний материал	3,122,540.00	811,605.00
35470	Бусад хангамжийн материал	1,346,260.00	1,478,680.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,298,232,157.46	4,114,745,848.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,298,232,157.46	4,114,745,848.53
392	Биет хөрөнгө	4,237,102,157.58	4,053,695,848.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,353,510,164.70	4,312,154,131.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	(338,964,251.18)	(455,460,820.58)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	222,579,489.00	224,773,009.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(133,596,898.17)	(151,776,076.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	180,694,206.80	166,163,379.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,720,540.17)	(71,757,760.96)
39217	Ном	29,599,986.60	29,599,986.60
393	Биет бус хөрөнгө	61,129,999.88	61,049,999.84
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.12)	(380,000.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	60,880,000.00	60,880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,409,128,554.92	4,230,203,196.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,409,128,554.92	4,230,203,196.21
51	Засгийн газрын хувь оролцоо	4,409,128,554.92	4,230,203,196.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,320,160,008.53	2,320,160,008.53
51101	Өмч: - төрийн	2,320,160,008.53	2,320,160,008.53
512	Хуримтлагдсан үр дүн	1,628,793,394.67	1,489,001,601.51
51210	Өмнөх үеийн үр дүн	1,628,793,394.67	1,667,926,960.22
51220	Тайлант үеийн үр дүн	-	(178,925,358.71)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	460,175,151.72	421,041,586.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,409,128,554.92	4,230,203,196.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,274,174,866.00	1,171,204,498.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,932,112.00	29,980,853.22
120	Нийтлэг татварын бус орлого	79,932,112.00	29,980,853.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,932,112.00	29,980,853.22
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	79,932,112.00	25,170,152.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал		4,810,701.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,194,242,754.00	1,141,223,645.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,089,763,700.00	1,051,042,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,089,763,700.00	1,051,042,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,425,454.00	4,625,945.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,089,754.00	4,625,945.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,335,700.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	80,053,600.00	85,555,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	80,053,600.00	85,555,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,403,807,554.93	1,325,240,330.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,403,807,554.93	1,325,240,330.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,299,979,848.41	1,261,997,350.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	869,055,837.00	855,829,810.00
210101	Үндсэн цалин	753,021,658.00	749,798,011.00
210104	Урамшуулал	74,621,142.00	62,680,005.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,413,037.00	43,351,794.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,486,556.94	112,183,619.86
210201	Тэтгэврийн даатгал	82,198,659.94	79,310,998.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,080,000.00	8,229,616.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,129,240.00	6,583,579.28
210204	Ажилгүйдлийн даатгал	1,734,593.00	1,642,362.82
210205	Эрүүл мэндийн даатгал	17,344,064.00	16,417,062.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,940,343.54	55,045,677.95
210301	Гэрэл, цахилгаан	13,207,943.54	12,335,177.95
210302	Түлш, халаалт	66,446,000.00	42,656,500.00
210303	Цэвэр, бохир ус	286,400.00	54,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,379,310.00	12,716,521.00
210401	Бичиг хэрэг	929,000.00	986,585.00
210402	Тээвэр, шатахуун	2,898,160.00	1,535,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	708,850.00	563,260.00
210404	Ном, хэвлэл	5,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	880,000.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,958,300.00	8,881,426.00
2105	Нормативт зардал	27,051,310.00	34,627,087.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	207,900.00	792,400.00
210502	Хоол, хүнс	24,934,410.00	31,419,687.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,909,000.00	2,415,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	148,500.00	1,563,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	70,000.00	888,100.00
210604	Урсгал засвар	78,500.00	675,000.00
2107	Томилолт, зочны зардал	916,000.00	426,000.00
210702	Дотоод албан томилолт	916,000.00	426,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,803,200.00	513,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,007,200.00	513,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	202,198,790.93	189,092,534.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	994,500.00	3,775,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	201,204,290.93	185,316,934.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,827,706.52	63,242,980.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,359,054.00	21,948,707.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,109,300.00	18,342,707.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,089,754.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,160,000.00	3,606,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,712,756.46	20,641,022.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,712,756.46	20,641,022.05
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,755,896.06	20,653,251.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,755,896.06	20,653,251.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(129,632,688.93)	(154,035,832.18)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	45,294,643.76	24,889,526.53
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	45,294,643.76	24,889,526.53
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(45,294,643.76)	(24,889,526.53)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(174,927,332.69)	(178,925,358.71)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,320,160,008.53	460,175,151.72	1,628,793,394.67	0.00	4,409,128,554.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,320,160,008.53	460,175,151.72	1,628,793,394.67	0.00	4,409,128,554.92
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,320,160,008.53	460,175,151.72	1,628,793,394.67	0.00	4,409,128,554.92
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,320,160,008.53	460,175,151.72	1,628,793,394.67	0.00	4,409,128,554.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	39,133,565.55	0.00	39,133,565.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,320,160,008.53	460,175,151.72	1,667,926,960.22	0.00	4,448,262,120.47
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-39,133,565.55	0.00	0.00	-39,133,565.55
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-178,925,358.71	0.00	-178,925,358.71
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,320,160,008.53	421,041,586.17	1,489,001,601.51	0.00	4,230,203,196.21

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,195,242,754.00	1,141,223,645.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,195,242,754.00	1,141,223,645.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,089,763,700.00	1,051,042,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,089,763,700.00	1,051,042,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,425,454.00	4,625,945.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,089,754.00	4,625,945.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,335,700.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	80,053,600.00	85,555,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	80,053,600.00	85,555,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,195,242,754.00	1,139,673,645.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,195,242,754.00	1,139,673,645.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,091,415,047.48	1,076,430,664.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	869,055,837.00	855,829,810.00
210101	Үндсэн цалин	753,021,658.00	749,798,011.00
210104	Урамшуулал	74,621,142.00	62,680,005.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,413,037.00	43,351,794.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,486,556.94	112,183,619.86
210201	Тэтгэврийн даатгал	82,198,659.94	79,310,998.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,080,000.00	8,229,616.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,129,240.00	6,583,579.28
210204	Ажилгүйдлийн даатгал	1,734,593.00	1,642,362.82
210205	Эрүүл мэндийн даатгал	17,344,064.00	16,417,062.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,340,843.54	58,439,177.95
210301	Гэрэл, цахилгаан	13,207,943.54	12,335,177.95
210302	Түлш, халаалт	59,846,500.00	46,050,000.00
210303	Цэвэр, бохир ус	286,400.00	54,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,010,310.00	7,244,955.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,525,945.00
210402	Тээвэр, шатахуун	2,898,160.00	1,535,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	708,850.00	563,260.00
210404	Ном, хэвлэл	450,000.00	450,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	880,000.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,873,300.00	2,420,500.00
2105	Нормативт зардал	20,667,800.00	31,036,202.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	684,950.00	1,507,450.00
210502	Хоол, хүнс	19,482,850.00	29,128,752.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	761,500.00	6,877,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	70,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	513,000.00	332,000.00
210604	Урсгал засвар	248,500.00	6,475,500.00
2107	Томилолт, зочны зардал	916,000.00	426,000.00
210702	Дотоод албан томилолт	916,000.00	426,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,803,200.00	653,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,007,200.00	653,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,373,000.00	3,740,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,373,000.00	3,740,400.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,827,706.52	63,242,980.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,359,054.00	21,948,707.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,109,300.00	18,342,707.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,089,754.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,160,000.00	3,606,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,712,756.46	20,641,022.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,712,756.46	20,641,022.05
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,755,896.06	20,653,251.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,755,896.06	20,653,251.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	1,550,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,550,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,550,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,550,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,550,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(1,550,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,136,597,700.00	1,095,303,426.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,136,597,700.00	1,095,303,426.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,108,928,300.00	1,073,354,719.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	863,589,500.00	855,829,810.00
210101	Үндсэн цалин	755,860,800.00	749,798,011.00
210104	Урамшуулал	64,298,900.00	62,680,005.00
210105	Гэрээт ажлын хөлс	43,429,800.00	43,351,794.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,811,200.00	112,183,619.86
210201	Тэтгэврийн даатгал	81,843,400.00	79,310,998.60
210202	Тэтгэмжийн даатгал	8,241,400.00	8,229,616.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,593,300.00	6,583,579.28
210204	Ажилгүйдлийн даатгал	1,650,100.00	1,642,362.82
210205	Эрүүл мэндийн даатгал	16,483,000.00	16,417,062.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	79,055,700.00	58,439,177.95
210301	Гэрэл, цахилгаан	15,420,000.00	12,335,177.95
210302	Түлш, халаалт	62,835,700.00	46,050,000.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	54,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,148,500.00	6,919,010.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,538,000.00	1,535,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	790,000.00	563,260.00
210404	Ном, хэвлэл	450,000.00	450,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	750,000.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,420,500.00	2,420,500.00
2105	Нормативт зардал	33,653,000.00	31,036,202.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,915,000.00	1,507,450.00
210502	Хоол, хүнс	31,338,000.00	29,128,752.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,220,000.00	6,807,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	720,000.00	332,000.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	6,475,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,700,000.00	426,000.00
210702	Дотоод албан томилолт	1,700,000.00	426,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	690,000.00	653,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	690,000.00	653,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,060,400.00	1,060,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,060,400.00	1,060,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,669,400.00	21,948,707.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,669,400.00	21,948,707.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,869,400.00	18,342,707.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,800,000.00	3,606,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,625,945.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,625,945.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,625,945.00
2104	Хангамж, бараа материалын зардал	325,945.00
210401	Бичиг хэрэг	325,945.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,620,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,620,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,680,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,680,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,625,945.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,625,945.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,625,945.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Шилэн баланс аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудитор Б.Нямдорж гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв дадалд суралцах чадвар эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан. Улмаар зорилгоо биелүүлэхэд чиглэсэн 8 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 1,416.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 28.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 22.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын дүн болох 1,325.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 27.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 21.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4 хувиар буюу 179.4 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 115.4 сая төгрөг болж 5.4 сая төгрөгөөр өссөн нь барилгын засварын материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 108.9 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 4.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 108.7 сая төгрөгийн материалыг зарцуулж, 0.5 сая төгрөгийн бараа материалыг акталж утгажээ. Оны эцэст 115.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,794.1 сая төгрөг болж 53.6 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн өмчийн албаны шийдвэрээр 41.3 сая төгрөгийн барилга байгууламжийг худалдан борлуулж, 39.0 сая төгрөгийн тавилга, машин тоног төхөөрөмжийг шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,229.7 сая төгрөг болж 179.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 8 хувиар буюу 103.4 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй ирсэн хөрөнгө оруулалт холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,488.5 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,277.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 225.9 сая төгрөгөөр бууруулж, 1,051.1 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 1,136.5 сая төгрөгийн төсөв баталснаас 1,051.0 сая төгрөгийг улсын төсвөөс 85.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,051.0 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 85.5 сая төгрөг, нийт 1,136.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,095.3 сая төгрөгийг зарцуулж 20.6 сая төгрөгийг улсын төсөвт, 20.6 сая төгрөгийн орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,095.3 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 7.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 2.6 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 20.6 сая төгрөгөөр, нормативд зардлыг 2.6 сая төгрөгөөр, албан томилолтын зардлыг 1.7 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 5.7 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 4.6 сая төгрөгийн гүйлгээ хийгдэн, 1.6 сая төгрөгийг багаж техник хэрэгсэлд, 2.7 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийг орлого, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 209.1 сая төгрөгийн 38 мэдээллийг ил тод байршуулахаас 167.0 сая төгрөгийн 15 мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд НӨАТ-эй холбоотой анхан шатны баримтын ямар нэгэн зөрчил илрээгүй тул Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 59.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 132.5 сая төгрөгийн хариуцлага тооцох албан шаардлага, хуулийн байгууллагад шилжүүлсэн байна. Хуулийн байгууллагад шилжүүлсэн асуудлаас бусад шийдвэр хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн хэмнэлтийн горим, бараа материалын тайлангийн тулгалт, хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийг ажлын даалгаврын дагуу бэлтгэсэн, хөрөнгийн чанар, хугацаандаа нийлүүлсэн эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.0 сая төгрөгийн алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад бараа материалын тайланд акталж устгасан бараа материалыг бусад ангилалд бүртгэсэн 0.4 сая төгрөг, үнэ төлбөргүй ирсэн 0.6 сая төгрөгийн бараа материалыг орлого аваагүй алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Багш нарын амралтыг буруу тооцон 0.4 сая төгрөгийг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Хоолны зардал 0.6 сая төгрөгийг үдийн цайны зардлаас гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн

сайдын 2014 оны 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаалтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 75 мэдээллээс 55 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 139.7 сая төгрөгийн 14 орлогын гүйлгээ, 27.3 сая төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, 42.0 сая төгрөгийн худалдан авалтын 4 мэдээллийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т ".цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" мэдээлнэ гэж заасан заалтыг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тайлангаар 2.6 сая төгрөгийн дутуу, 1.9 сая төгрөгийн илүү төлөлттэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургууль	7	6.6	2	1.0	1	0.4	4	5.2		
	Дүн	7	6.6	2	1.0	1	0.5	4	5.2		